



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар A/3

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг томилох тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Багахангай дүүргийн Өндөр довд байршилтай, Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, "Хангайхан Өндөр" ХХК-ийн түрээсээр эзэмшиж байсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай газар дээр нь танилцаж, цаашид хөрөнгийн ашиглалт, арчлалт хамгаалалтыг хэрхэн хариуцах талаар санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Дэлгэрмаа	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Гишүүн:	М.Нямсүрэн	Мэдээлэл, технологийн албаны мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Д.Батболд	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

2. "Хангайхан Өндөр" ХХК-ийн түрээсээр эзэмшиж байсан барилга байгууламжийн ашиглалтын байдалтай газар дээр нь танилцаж, цаашид хөрөнгийн ашиглалт, арчлалт хамгаалалтыг хэрхэн хариуцах талаар санал дүгнэлт гарган 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг /Д.Дэлгэрмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨБЗГ тушаал-/2022

132013510